

8.6.4 Хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл.

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Хянан баталгааны төрөл: Захиалгат хянан баталгаа **Огноо:** 2022-08-17

1. Газар ашиглагч: Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв ТӨААТҮГ
2. Аймаг (нийслэл): Улаанбаатар **Сум (дүүрэг):** Хан-Уул
3. Байршил, хаяг: 3 дугаар хороо, Ажилчны гудамж
4. Нэгж талбарын дугаар: 1780911155
5. Хөрсний нэр:
6. Ургамалжилт:
7. Нийт талбайн хэмжээ: 23759 м²
8. Газар эзэмших зориулалт: Биеийн тамир, спортын байгууллага
9. Одоогийн газар ашиглалтын хэлбэр: Биеийн тамир, спортын байгууллага
10. Газар ашиглах, эзэмших шийдвэр: Улаанбаатар аймаг /нийслэл/-ийн Хан-Уул сум/дүүргийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01122-А/937/2015 тоот захирамж
11. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар: 438719
12. Эзэмшил газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт

Ажилчны гудамжны баруун талд 3м орчим зайд, газрын гадарга нь 0-2 градусын налуутай, д.т.д 1279-1278 метрийн өндөрт байрлана. Нэгж талбарын зүүн урд болон баруун талд барилга байгууламж, баруун урд болон баруун хойд талд спортын сургалтын талбай зэрэг байрлаж байна. Зүүн урд талаасаа орц гарцтай.

Газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт

Газар ашиглалтын байдал	Талбай	Эвдэрч бохирдсон талбай		
		Физикийн	Химийн	Биологийн
Нийт эзэмшил газар	-	-	-	-
Нэгж талбарын талбай	23768	-	-	-
Газар дээрээ ашиглаж байгаа талбай	-	-	-	-
Дутуу ашиглаж байгаа газар	-	-	-	-
Илүү ашиглаж байгаа газар	778	+	-	-
А.Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай				
1.Үйл ажиллагаанд өртөөгүй талбай				
Сул чөлөөтэй талбай	644	-	-	-
Ногоон байгууламж	3757	-	-	-
2.Үйл ажиллагаанд өртсөн талбай				
Барилга байгууламж	3910	+	-	-
Сургалтын талбай	5262	+	-	-
Б.Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа талбай				

1.Үйл ажиллагаанд өртөөгүй талбай				
Сул чөлөөтэй талбай	644	-	-	-
2.Үйл ажиллагаанд өртсөн талбай				
Байшин	134	+	-	-

Нэгж талбарын зүүн урд болон баруун талд барилга байгууламж, баруун урд болон баруун хойд талд спортын сургалтын талбай зэрэг байрлаж байна. Зүүн урд талаасаа орц гарцтай.

13. Газар ашиглалтын онцлог, гадаргын төлөв байдал

Ажилчны гудамжны баруун талд 3м орчим зайд, газрын гадарга нь 0-2 градусын налуутай, д.т.д 1279-1278 метрийн өндөрт байрлана.

14. Хөрсний доройтол, бохирдолт, түүний төрөл, зэрэглэл

Нэгж талбарт 2 цэгээс хөрсний зүсэлт хийж, 5 үзүүлэлт бүхий хөрсний дээж авч "Инженер геодези" ХХК магадлан итгэмжлэгчдсэн лабораторид 08 дугаар сарын 18-23 өдрүүдэд 22/3143 шинжилгээ өгсөн.

Хөрсний механик бүрэлдэхүүн

Цэгийн дугаар	Давхарга	Гүн см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар						
			1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	0.001-с бага	0.01-с бага
1780911155001001	А	0-20	4.0	3.2	8.8	23.5	38.6	21.9	16.0
1780911155001002	А	0-20	4.5	4.9	7.2	22.2	41.8	19.4	16.6

Аллювийн нугын сулавтар хөгжилтэй хөрсний хатуу хэсгийг бүрдүүлж байгаа жижиг ширхэгүүд болох нарийн бүдүүн элс (1.0-0.05 мм), физик шаврын (0.01 мм) харьцаанаас үзэхэд элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй.

Хөрсний агрохимийн шинж чанар

Цэгийн дугаар	Давхарга	Гүн см	Ялзма г, %	рН	ЦДЧ dsm	Давс, %	CaCo ₃ , %	Солилцох суурь, мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
								Ca	Mg	K ₂ O	p ₂ O ₅
1780911155001001	А	0-20	1.69	8.4	0.296	0.14	0.64	10.4	8.6	36	1.8
1780911155001002	А	0-20	1.58	8.53	0.25	0.12	0.64	18.3	4.5	39	1.8

хөл газрын ургамал болох Агь-Artemisia absinthium, Ээрэм шарилж-Artemisia macrocephala Jacquem., Шүлхий шарилж-Artemisia pectinata, Ишгэн шарилж-Artemisia dracunculus L. зэрэг түрж ургасан байна. Харин өөрийн эзэмшил газарт ногоон байгууламж бий болгож, засаж сайжруулсан хэсэгт Мөлхөө хиаг-Elymus repens L., Ботууль-Festuca lenensis, улиас мод зэрэг тариалсан байна.

16. Усны чанар, төлөв байдал

Ил задгай урсацтай гол горхи байхгүй болно.

16. Газар ашиглалтын зөрчил, аюулгүй байдал:

Нэгж талбарын зүүн талаар зохих зөвшөөрөлгүйгээр дур мэдэж байшин барьж, илүү талбай ашиглаж байна. Галын аюулгүй байдал зөрчигдөөгүй байна.

17. Газар ашиглалтын талаар цаашид авах арга хэмжээ, зөвлөмж

Дээрх газрын зөрчлийг арилгахад Газрын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх шаардлагатай. Цаашид баригдах барилга байгууламжийн зураг төсөл нь хот, тосгоны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шийдлүүд, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай уялдсан байх бөгөөд барилгажих талбай нь тухайн газрын 70 хувиас илүүгүй байна. Газар эзэмшүүлэх гэрээнд тусгагдсан газар эзэмшигчийн үүргийн дагуу хот тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламж бий болгох, Эзэмшил, ашиглалтанд байгаа болон орчны 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжид тохижилт, арчилгаа хийж байх, Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд тусгагдсан ажлуудыг жил бүрийн ажлын төлөвлөгөөндөө тусгаж ажиллах. Цаашид газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх, газрын талбайн хэмжээ болон зориулалтыг өөрчлөхгүй байх, бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх, бусдын болон нийтийн эзэмшлийн зам талбайн орц гарцыг чөлөөтэй байлгах, “Газрын тухай хууль”-ийн 58 дугаар зүйлд заасны дагуу 5 жил тутамд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг хийлгүүлж байх шаардлагатай.

БАТАЛГААЖСАН.



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР /Газар ашиглалт, газрын төлөв
байдал, чанарын хянан баталгаа хариуцсан
мэргэжилтэн/